



СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу.**

Үндэсний аудитын газрын
Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас:261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд
Утас:261885
Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Аудитор: Г.Жавхлан
Утас:261628
Цахим хаяг: javkhlant@audit.gov.mn

Үндэсний аудитын газрын хаяг:
Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160,
Монгол Улс

Цахим хуудас: audit.mn

2015 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. /САГ-2016/13/САГ-ЗГТС/

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сургалтын төрийн сангийн төсвийн захирагчийн 2015 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 03 дугаар сарын 05-наас 2016 оны 03 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Жавхлан хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 03 дугаар сарын 04-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитын тайланг хуулийн хугацаанд Сургалтын төрийн сангийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Сургалтын төрийн сангийн төсвийн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиуд, Засгийн газрын 2011 оны 102 дугаар “Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2011 оны 217 дугаар “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам батлах тухай” зэрэг тогтоолуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Төсвийн тухай хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааны чиглэлийг Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3, 16.4-т “16.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд суралцагчид олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагчдын тоо, сургалтын төлбөрийн жишиг хэмжээг харгалзан энэ хуулийн 16.1-д заасан санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан сангийн хөрөнгийг улсын төсвөөс хуваарилсан хэмжээгээр Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

16.4. Сургалтын төрийн сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар батална.” гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т “Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна”, 16.4.17-д “Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн” гэж тус тус заасны дагуу Сургалтын төрийн сангийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж ирсэн байна.

Сургалтын төрийн сангийн 2015 оны төсвийг БСШУЯ-ны төрийн сангаас олгосон байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааны талаар /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг нийт зардлын 2% буюу 1,210.5 сая төгрөгөөр тогтоов.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, авлага, цалин, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал дансдад аудитын 6 горимыг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. Олон улсын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Сургалтын төрийн сан нь нягтлан бодох бүртгэлийн Acolous програм ашигладаг бөгөөд Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын дагуу төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сургалтын төрийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс урсгал зардалд 58,324.5 сая төгрөгийн санхүүжилт авч, төсвийн урамшуулалд 8.0 сая төгрөг, өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,902.8 сая төгрөг зэрэг нийт 60,235.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнээс 59,426.6 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт эрсдэлүүдээс авлагын данс 1, цалингийн данс 3, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлын данс 3 данс нийт 7 уламжлалт эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж тооцсон ба батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 3, нарийвчилсан 3 зэрэг нийт 6 аудитын горимыг гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- Авлагын насжилт их байх
- Цалингийн тушаал буруу гарсан байх
- Ажлын цагийг буруу бүртгэснээс цалин буруу бодогдож олгогдсон байх

- НДШ, ХХОАТ-ыг бодож суутгасан байх
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлын тооцооллыг буруу хийсэн байх
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан байх
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал холбогдох анхан шатны баримтын бүрдэлгүй байх

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2015 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний авлага, цалин, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын дансыг шалгаж баримтжуулав. /ТАБ-СТА-В-3/.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Төсвийн 111,994.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах” гэж заасныг зөрчсөн байна. Авлагыг хүснэгтээр үзүүлбэл:

/хэмжих нэгж сая төгрөгөөр/

Он	Өндөр хөгжилтэй оронд суралцагчдаас авах авлага	Дотоодын их дээд сургууль, коллежид суралцагчдаас авах авлага	Өндөр хөгжилтэй оронд суралцагчдаас авах хүүгийн авлага	Нийт дүн
1994-2004	20,046.0	3,886.2		23,932.2
2004-2015	56,694.0	17,672.0	13,695.8	88,061.8
Нийт дүн	76,740.0	21,558.2	13,695.8	111,994.0

Нийт авлагын 68.5 хувь буюу 76,740.0 сая төгрөгийг өндөр хөгжилтэй оронд суралцагчдаас авах авлага, 19.2 хувь буюу 21,558.2 сая төгрөгийг дотоодын их, дээд сургууль, коллежид суралцагчдаас авах авлага 12.3 хувь буюу 13,695.8 сая төгрөг эзэлж байна.

Үүнээс дотоодын их дээд сургууль, коллежид суралцагчдаас авах авлага нь тухайн суралцагчийн дипломын барьцаагаар, 2004 оноос хойш өндөр хөгжилтэй оронд суралцагчдаас авах авлага нь үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан учраас эргэн төлөгдөх, Засгийн газрын тогтоолоор чөлөөлөгдөх бүрэн боломжтой байна. Харин 1994-2004 онд өндөр хөгжилтэй оронд суралцагчдаас авах 20,046.0 сая төгрөгийн авлага нь насжилт их, ямарваа нэгэн барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй, эргэн төлөгдөх, Засгийн газрын тогтоолоор чөлөөлөгдөх магадлал багатай,

эрсдэл ихтэй учраас Сургалтын төрийн сангийн удирдлага дээрх авлагыг барагдуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах нь зүйтэй.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

2. Сургалтын төрийн сангийн сангийн төсвийн санхүүгийн тайланд 3.4 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 4.9 сая төгрөгийн шатахуун зэрэг нийт 8.3 сая төгрөгийн зардлыг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн нь УСНББОУС-12, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.21-т заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

3. Сургалтын төрийн сан нь “Санхүүгийн тооцоолох” ХХК-иас 1.4 сая төгрөгөөр худалдан авсан санхүүгийн ACOLOUR програмыг төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орлого аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, УСНББОУС 17-ийн Т6 заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

4. Сургалтын төрийн сангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолыг мөрдөж байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар 20,046.0 сая төгрөгийн авлага барагдуулалтын талаар зохион байгуулсан ажлын үр дүнг нягтлан шалгаж дүгнэлт өгнө..

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 20,055.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 4 зөвлөмжийг өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Сургалтын төрийн сангийн 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын аудитор Ж.Болормаа аудит хийж “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн бөгөөд аудитаар өгөгдсөн 3 зөвлөмжийн 2 нь хэрэгжиж, 1 нь хэрэгжих шатандаа байна.

Зөвлөмж:

Сургалтын төрийн сангийн удирдлагад өгөх 4 зөвлөмжийг менежментийн захидалд дэлгэрэнгүй харуулсан.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.



СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Авлага.....	2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2	
Бараа материал.....	3

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3	
Үндсэн хөрөнгө.....	3

Тэргүүлэх ач холбогдол №4 зүйлс:

Асуудал 4	
НББ-ийн бодлогын бичиг баримт.....	3

2010 оны 3 дугаар сарын
01

2015 оны 03 дугаар сар

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараахь хаягаар
харилцана уу:
Газрын захирал:

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Сургалтын төрийн сангийн төсвийн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Сургалтын төрийн сангийн удирдлага, холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

1994-2004 онд өндөр хөгжилтэй оронд суралцагчдаас авах 20,046.0 сая төгрөгийн авлага нь насжилт их, ямарваа нэгэн барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй, эргэн төлөгдөх, Засгийн газрын тогтоолоор чөлөөлөгдөх магадлал багатай, эрсдэл ихтэй учраас Сургалтын төрийн сангийн удирдлага дээрх авлагыг барагдуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах нь зүйтэй.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгөөс олгогдсон зээл эргэн төлөгдөхгүй байх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах” гэж заасныг мөрдөж ажиллах, авлагын эргэн төлөлтийг бүрэн дүүрэн хангуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Сургалтын төрийн сангийн төсвийн захирагчийн санхүүгийн тайланд 3.4 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 4.9 сая төгрөгийн шатахуун зэрэг нийт 8.3 сая төгрөгийн зардлыг бараа материалын дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн нь УСНББОУС-12, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.21-т заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС-12 ба 17, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.21-ийг тус тус мөрдөж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Сургалтын төрийн сан нь “Санхүүгийн тооцоолох” ХХК-иас 1.4 сая төгрөгөөр худалдан авсан санхүүгийн ACOLOUR програмыг төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орлого аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, УСНББОУС 17-ийн Т6 заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Дотоод хяналтын тогтолцоо сулрах,

төсвийн сахилга бат алдагдах, бараа

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, УСНББОУС 17-ийн Т6 заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Сургалтын төрийн сангийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолыг мөрдөж байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу
илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Сургалтын төрийн сангийн онцлогт тохирсон үндсэн хөрөнгийг элэгдүүлэх аргачлалыг боловсруулж НББ-ийн бодлогын баримт бичигт тусгах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН
ЗАХИРАЛ П.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016.03.25 № 3/538
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сургалтын төрийн сан нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сургалтын төрийн сангийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10-10-20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0325SAG28.Docx

УХА0122

070557